



Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн бусад зөвлөмжтэй дараах QR кодыг ашиглан танилцана уу.

ЖИЛИЙН ТАЙЛАН

2020 ОН

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

АГУУЛГА

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

НЭГ. ОРШИЛ	1
ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА	3
2.1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өгсөн санал, дүгнэлт	3
2.2.Төсвийн төсөл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд өгсөн дүгнэлт, санал	4
ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА	11
ДӨРӨВ. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ	12
ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА	13
ЗУРГАА. ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД	16
ДОЛОО. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД (САНАЛ, ЗӨВЛӨМЖ, ТАНИЛЦУУЛГА)	21



“Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны 10, II тоот тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүдийг томилсноор зөвлөлийн үйл ажиллагааг эхлүүлэв”.

НЭГ. ОРШИЛ

Эрх зүйн үндэслэл: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (цаашид ТТБЗ гэж товчлох) 2020 онд Монгол Улсын төсвийн сахилга батыг бэхжүүлэх, төсөв, санхүү, эдийн засгийн байдлыг сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх зорилго тавьж ажиллан хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа. Тус зөвлөлийн хийх ажлын хүрээг хууль зүйн хувьд дараах байдлаар тогтоосныг 2020 онд бүрдсэн УИХ-ын Төсвийн Байнгын Хороонд дахин танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний 69 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, Засгийн газраас өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийн төсөл, түүний тодотгол, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл болон бусад хууль тогтоомжийн төслийн төсөвт нөлөөлөх байдалд хараат бус, бие даасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргах үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулж, зөвлөлийн дүрэм, гишүүдэд тавих шаардлага, томилох журмыг батлан гаргахыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хооронд даалгасан байдаг. Энэ заалтыг хэрэгжүүлэх үүднээс Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны 83 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөн ажиллаж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн:

3.1.1-д: Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эрхлэх асуудалд УИХ-ын 2017 оны 69 дүгээр тогтоолоор тодорхойлсон дээр дурдсан ажил үүргээс гадна “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэхэд судалгаа шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана”,

3.1.2-т: “УИХ-ын холбогдох Байнгын хорооны хүсэлтийн дагуу шаардлагатай тохиолдолд тодорхой асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргана”,

3.1.3-т: “Зөвлөл гаргасан дүгнэлт, зөвлөмжөө УИХ-ын холбогдох Байнгын хороонд хүргүүлснээс хойш 3 хоногийн дотор олон нийтэд мэдээлж, тайлбар хийж болно”,

6.1-д: “Зөвлөл нь УИХ-ын Төсвийн байнгын хороог энэ дүрэмд заасан судалгаа, шинжилгээний дүгнэлт, зөвлөмж, холбогдох бусад мэдээллээр хангаж ажиллана”,

6.2-т: “Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт болон үйл ажиллагааныхаа талаар хагас жил тутамд УИХ-ын Төсвийн байнгын хороонд тайлагнана”,

6.3-т: “УИХ-ын ТБХ Зөвлөлийн гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар шаардлагатай гэж үзвэл Засгийн газраас холбогдох тайлбарыг гаргуулж авна”,

6.4-т: “Зөвлөлийн үйл ажиллагаанд УИХ-ын ТБХ-ны дэргэдэх Төсвийн шинжилгээний алба дэмжлэг үзүүлж, мэдээ, мэдээллээр хангаж ажиллана” гэж тус тус заажээ.



Анхаарал хандуулсан асуудал: Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг хяналтаас гаргахгүй байх, түүгээр дамжуулан өр үүсгэх явдлыг хязгаарлах, ТТБЗ-ийн институцийнх нь ач холбогдлыг олон нийт, төрийн түшээдэд танилцуулах, үйл ажиллагаандаа олон улсын дэмжлэгийг авах, төсөв, эдийн засгийн байдлыг хэвийн явуулах чиглэлээр санал дүгнэлт

“ТТБЗ-ийн институцийнх нь ач холбогдлыг олон нийт, төрийн түшээгдэд танилцуулах, үйл ажиллагаандаа олон улсын дэмжлэгийг авах, төсөв, эдийн засгийн байдлыг хэвийн явуулах чиглэлээр санал дүгнэлт гаргаж, төр засагт санал, дохио өгөхийг хичээн ажилласан болно”.

“Зээл тэглэх, тэтгэмж олгох зэрэг гэнэтийн шинжтэй шийдвэрийн улмаас төсвийн данс дундарч, улмаар мөнгө, төсөв, эдийн засгийн байдалд урт, дунд хугацаандаа эрсдэл дагуулсан жил байв”.

Хүснэгт (№1-7, 16-20 хуудас)

Төсөв, төлбөрийн тэнцэл, гадаадын хөрөнгө оруулалттай холбогдсон 2020 оны урьдчилсан мэдээллийг харуулав.

гаргаж, төр засагт санал, дохио өгөхийг хичээн ажилласан болно. Гэвч Монгол Улсын хувьд 2020 он онцлогтой, сонгуулийн болон цар тахлын улмаас төсөвт томоохон ачаалал өгсөн жил болж өнгөрлөө.

Ковид-19 цар тахлаас үүсэлтэй эдийн засаг, санхүүгийн хүндрэлийг давахын тулд Монголын төр, засаг дотоод гадаадын санхүүгийн бүх сувгийг ашиглан тэмцэж байна. Иргэдийнхээ аж амьдралын хүндрэлийг давах туулах, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, татварын болон зээлийн дарамтыг хөнгөвчлөх үүднээс хүн амд очих бэлэн мөнгөний урсгалыг өргөжүүлж нэмэгдүүлэх, төсвийн зардлын санхүүжилтийг эрэмбэлж, эрүүл мэндийн салбарын техникийн чадавхыг нэмэгдүүлэх, цалин тэтгэвэр, хүүхдийн мөнгө, халамжид тасалдал гаргахгүй байх, иргэд аж ахуйн үндсэн хэрэглээ болсон цахилгаан, дулаан, ус, түлшний үнийг төрөөс хариуцах, татвар, нийгмийн даатгалын шимтгэл, бусад татвар хураамжийг чөлөөлөх, багасгах, эдийн засагт нийлүүлэгдэх хөрөнгө мөнгийг зорилтжуулах, нэмэгдүүлэх, хямдруулах, зарим зээлийн төлбөрийг чөлөөлөх, хойшлуулах, нөхцлийг нь өөрчлөх зэрэг олон төрлийн арга хэмжээ авч байна.

Ийм том цар хүрээтэй арга хэмжээний санхүүжилтийг гаргахад 2017-2019 оны улсын нэгдсэн төсөв ашигтай болж, эдийн засаг, санхүүгийн байдалд нааштай өөрчлөлтүүд гарч, мөнгө санхүү, валютын зохих нөөц бүрдсэн байсан болон таваарын бүтээгдэхүүний үнэ, валютын ханшийн төсвийн эерэг нөлөөлөл, зарим талын олон улсын хамтын ажиллагааг цаг хугацаанд эрчимжүүлж чадсан явдал байлаа. Гэвч тоо хэмжээ нь нэмэгдэж хавтгайрсан, цаг хугацааны хувьд олон сараар үргэлжилсэн халамжийн болон нийгмийн арга хэмжээ, мэргэжлийн байгууллагын санал, оролцоо тодорхойгүй тэтгэврийн зээл тэглэх, тэтгэмж олгох зэрэг гэнэтийн шинжтэй шийдвэрийн улмаас төсвийн данс дундарч, улмаар мөнгө, төсөв, эдийн засгийн байдалд урт, дунд хугацаандаа эрсдэл дагуулсан жил байв.

Төсвийн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээс үзэхэд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого **9,421.6** тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зарлага **13,960.8** тэрбум төгрөг, алдагдал **4,539,1** тэрбум төгрөг болжээ. Энэхүү алдагдлын **2,142.6** тэрбум төгрөгийг Засгийн газар төсвийн дансны үлдэгдлээс, **2,481.5** тэрбум төгрөгийг өрийн хэрэгслээр, **138.8** тэрбум төгрөгийг тогтворжуулалтын сангаас, **25.7** тэрбум төгрөгийг өмч хувьчлалын орлогоос тус санхүүжүүлсэн байна.

Тайлант оны төсвийн алдагдал өмнөх 2019 оны алдагдлаас **3,782.9** тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол тэнцвэржүүлсэн орлого нь **1,483.9** төгрөгөөр буурсан байна. Эдгээр шалтгааны улмаас төсвийн дансдын нөөцийг байж болох хэмжээнд дайчлан ашигласан ч батлагдсан төсвийн зардлын 8 шахам хувь буюу **1,145.4** төгрөгийг дутуу зарцуулжээ. Энэ нь цар тахлын тухай хуулийн дагуу зардлыг эрэмбэлэх, төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан санхүүжилт олгож ирснээр төсөв хяналтаас гарчихаагүйч 2021 оноос төсвийн хяналтыг улам чангатгах, төсвийн орлогын дийлэнхийг бүрдүүлдэг уул уурхай, экспортын үйлдвэрлэл, нийлүүлэлтэд огт тасалдал гаргаж болохгүй болохыг дээрх тоо баримтууд гэрчилж байна. Өөр нэг эрсдэл дагуулж буй зүйл бол үнэ цэнийн бууралтыг тооцож, Монголбанкны алдагдлыг нэмэгдүүлдэг өрийн бичиг, үүсмэл үнэт цаасны нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж байна.

Тухайлбал, Тэтгэврийн зээл тэглэхэд зориулан гаргаж, Монголбанкнаас санхүүжилт авсан **694.9** тэрбум төгрөгийн Эрдэнэс бонд, түүнчлэн Нийслэлийн орон сууцны бонд зэрэг болно.

“Төсвийн иж бүрдлийг хангах, төсвийн гадуурх санхүүжилт гаргуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах нь ТТБЗ-ийн өнөөгийн тулгамдсан зорилт болж байна”.

Төсвийн иж бүрдлийг хангах, төсвийн гадуурх санхүүжилт гаргуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах нь ТТБЗ-ийн өнөөгийн тулгамдсан зорилт болж байна. Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр УИХ-аас төсвийн зардал, алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх хязгаарлалт хийсэн. Ингэснээр Засгийн газар төсвийн удирдлагыг хуулийн хүрээнд зөв хийж байх шаардлагатай болж байна.

ХОЁР. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр өгсөн санал, дүгнэлт

“ТТБ хуулийн үндсэн зорилт бол нэгдсэн төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас, Засгийн газрын өрийг 40 хувиас хэтрүүлэхгүй байх, эрдэс түүхий эдийн үнийн өсөлтийг дагуулан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байхаар хуульчилсан төсвийн тусгай шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөх юм”.

Төсвийн тогтвортой байдлын тухай (ТТБХ) 2010 онд батлагдсан хуулийн үндсэн зорилт бол нэгдсэн төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас, Засгийн газрын өрийг 40 хувиас тус тус хэтрүүлэхгүй байх, эрдэс түүхий эдийн үнийн өсөлтийг дагуулан төсвийн зардлыг нэмэгдүүлэхгүй байхаар хуульчилсан төсвийн тусгай шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөн ажиллах үндсэн дээр **эрдэс баялгийн орлогоор нөхөн сэргээгдэх баялаг бүтээх, эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт хийх, санхүүгийн хуримтлал бүрдүүлэхэд** оршиж байгаа билээ. Энэхүү зорилт хангалтгүй хэрэгжиж ирсэн учраас 2017 оны эцсээр ТТБЗ-ийг байгуулж, үйл ажиллагааг нь 2018 оноос эхлүүлсэн юм. Өнгөрсөн 2018, 2019 онуудад Засгийн газар төсвийн тусгай шаардлагуудыг хангаж ажилласан болохыг тэмдэглэж байна. Харамсалтай нь 2020 онд цар тахал, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн нөлөөллөөс хамааран Монгол Улсын Төсвийн алдагдал ямар хэмжээнд хүрснийг дээр дурдсан. Ийм байдлыг дахин гаргуулахгүйгээр төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг буцаан хэвийн байдалд оруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах нь Төсвийн Байнгын Хорооны үндсэн зорилт бөгөөд энэ зорилтыг хэрэгжүүлэхэд ТТБЗ-ийн үйл ажиллагаа бүхэлдээ чиглэх болж байна.

Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн дараах дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

“Эдийн засгийн өсөлт 0 буюу түүнээс бага болох, гашигийн аюул үүсч гарах зардал нь ДНБ-ний 5 хувиас дээш гарсан, гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 15 хувь ба түүнээс дээш хувиар унах нөхцөлүүсээгүй бол төсвийн шалгуур үзүүлэлтийг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газар УИХ-д оруулж шийдүүлэх хуулийн заалттай”.

- 1) Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Улсын Их Хурлаас олон удаа өөрчлөлт оруулж, төсвийн алдагдал, засгийн газрын өрд хамаарах шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөхийг түдгэлзүүлж иржээ. Ийнхүү түдгэлзүүлэх болсон шалтгаан нь хуульд зааснаар эдийн засгийн өсөлт 0 буюу түүнээс бага болох, гамшигийн аюул үүсч гарах зардал нь ДНБ-ий 5 хувиас дээш гарсан, гадаад валюттай харьцах төгрөгийн ханш 15 хувь ба түүнээс дээш хувиар унах явдал байдаг. Эдгээр хүндрэлтэй нөхцөл цар тахлын уршигтай 2020 оныг эс тооцвол Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсан 2010 оноос хойш бараг тохиолдоогүй гэж болно. Нөгөө талаар дээрх нөхцөл арилсан үед төсвийн шалгуур үзүүлэлтийг түдгэлзүүлсэн шийдвэрийг хүчингүй болгох асуудлыг Засгийн газар УИХ-д оруулж шийдүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлдэггүй байжээ гэсэн дүгнэлт гарсан юм.
- 2) Шалгуурыг түдгэлзүүлэх нөхцөл арилсан үеэс эхлэн хуульд заасан үндсэн шалгуур үзүүлэлтүүд болох төсвийн алдагдлыг ДНБ-ий 2 хувиас хэтрүүлэхгүй байх, гадаад өрийн үлдэгдэл 40 хувь байх

“Шалгуурыг түдгэлзүүлэх нөхцөл арилсан үеэс эхлэн УИХ эдгээр түдгэлзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг сэргээх асуудлыг УИХ-д оруулахыг Засгийн газраас шаардах учиртай гэж үзлээ”.

заалтуудыг эргүүлэн хэрэглэх гэсэн санал дүгнэлтэд ТТБЗ хүрсэн бөгөөд УИХ эдгээр түдгэлзүүлсэн шалгуур үзүүлэлтүүдийг сэргээх асуудлыг УИХ-д оруулахыг Засгийн газраас шаардах учиртай гэж үзлээ. ТТБЗ төсвийн тусгай шаардлагууд (нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай эсхүл ашигтай байх /ТТБХ-6.1.2/, Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 60 хувиас хэтрэхгүй байх /ТТБХ-6.1.2./)-ыг өөрчилсөн тогтоолуудыг хүчингүй болгож, төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн анхны заалтуудыг сэргээх холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд оруулах саналыг Засгийн газарт 2019 онд хүргүүлсэн боловч нааштай шийдвэр гараагүй байгаа юм. Төсвийн шалгуур үзүүлэлтүүдийг мөрдөхийг түдгэлзүүлсэн эдийн засгийн нөхцөл арилж, хэвийн горимд оруулах асуудал Засгийн газрын бүтцийн хэд хэдэн яам, газруудын дунд хаягдаж, нэгдсэн зохицуулалт дутагдаж байна гэсэн дүгнэлт хийж байгаа. Үүнийг засах асуудлыг нарийвчлан авч үзэж, зохих шийдэл гаргахын төлөө ажиллах болно.

- 3) ТТБЗ төсвийн тогтвортой байдлын тухай шалгуур үзүүлэлтийг хуульд анхлан заасан хэмжүүрээр буюу Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдлыг 2 хувиас хэтрүүлэхгүй байх тухай санал, зөвлөмж, дүгнэлтийг УИХ-ын Төсвийн байнгын хороо, ОУВС, олон нийт, судлаачид, гадаад дотоодын холбогдох байгууллагын сонорт хүргэн ажиллаж байна.
- 4) Төсвийн урхагшсан алдагдал, эсвэл алдагдалтай ч төсвийн зардлыг нэмэгдүүлсээр байгаа нь эцсийн дүндээ өр зээл өсөх шалтгаан болсоор Монгол Улс өнөөдөр гадаад өрийн шалгуур үзүүлэлтүүдээр Дэлхийд хамгийн сүүлийн 3 байрт зогсож байна. Төсөв өөрөө зээлийн үйлчилгээний зардлаа даахгүй хэмжээнд хүрч, өрийн хямрал гарах эрсдэл өссөөр байна.
- 5) Монгол Улсын Засгийн газар, Монголбанк тулгамдсан өр зээлийг хойшлуулсан, бага хүүтэй бонд зээлийн хэрэгслээр дахин санхүүжилт хийж богино хугацаандаа хүндрэлийг зөөлрүүлсэн сайн талтай ч хойшилсон өр, нэмэгдсэн зээлийн үйлчилгээний төлбөр дарамт болж үлдсээр байгаа юм. Яваандаа зайлшгүй төлөгдөх, арилжааны нөхцөлтэй бондын төлбөрийг хичээж байгаад төлөөд байх нь санхүү, төсөв, эдийн засаг эрүүлжих, улмаар хөгжилд хүрэх саадыг арилгаж буй хэрэг үзэж байна. Хойшлуулаад, шинээр зээл авч өр барагдуулаад байвал төсөв улам хүндрээд байх болно.

Төсвийн төсөл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд өгсөн дүгнэлт, санал



Монгол Улсын Засгийн газраас өргөн барьсан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Монгол Улсын УИХ-ын 2020 оны сонгуулийн хугацаа давхцсан болон дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын дэгдэлт, тодорхойгүй байдлын улмаас 2020 оны 5 дугаар сард УИХ-аар хэлэлцэхийг түр хойшлуулсан.


1 Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын эдийн засгийг Ковид-19 цар тахлын үед хэрхэн удирдах, төсвийн байдлыг хямралд оруулахгүй байх, эрсдлийг бууруулах чиглэлээр судалгаа хийж

Хавсралт №1 (21-28 хуудас)

Коронавирусийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг саармагжуулах арга хэмжээний тухай" санал, зөвлөмж

“Коронавирусийн нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг саармагжуулах арга хэмжээний тухай” санал, зөвлөмжийг 2020 оны 03 дугаар сарын 17-ны өдөр УИХ-ын дарга болон Төсвийн байнгын хороонд 07 тоот албан бичгээр хүргүүлсэн (Хавсралт№1).

Уг санал, зөвлөмжид Монгол Улсын нийгэм, эдийн засагт үүсээд буй нөхцөл байдлыг тодорхойлоод гадны бусад улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, манай улс хэрхэн даван туулах боломжийг санал, зөвлөмжийн хэлбэрээр дараах байдлаар тусгасан болно. Тухайлбал:



- (а) Үүсээд буй хүндрэлийг боломж гэдэг талаас нь харж, Дэлхийн хамгийн том, тогтвортой зах зээлүүдтэй хаяа нийлэн амьдарч буй орны хувьд Монгол Улс байдлыг нааштайгаар эргүүлэхийг оролдох нь зүйтэй. Төрөөс гаргаж буй дипломатын болон гадаад худалдааны бодлогын хүчин чармайлтыг улам чамбайруулж, үр дүнд хүргэхийг хүсэж байна. Төсвийн орлогын тасалдлыг нөхөх, бүх шатны төсвийг дээд зэргийн арвилан хэмнэлтийн зарчимд шилжүүлэх чиглэлээр ажиллахад шаардлагатай эрх зүйн үндсийг бүрдүүлж, Засгийн газрыг шуурхай ажиллах боломжийг бүрдүүлж өгөх нь зүйтэй.
- (б) Засгийн газар, төр, захиргааны бүх байгууллага, хувийн хэвшил бүхэлдээ экспортын зарим бүтээгдэхүүний тасалдлыг нөхөж, төлөвлөсөн орлогын хэмжээнд хүргэх арга хэмжээг авч ажиллах, гадаад, дотоод талаас экспортод аливаа хязгаарлалт, саад хориг үүсэх нөхцлийг бүрэн хаах.
- (в) Ажлын байрыг хадгалах, дотоодын нөөц бололцоо ялангуяа, өвлийн улирал дуусаж, хавар зун, намрын ажлын бэлтгэлийн байдалд дүн шинжилгээ хийж холбогдох арга хэмжээ авах.
- (г) Төсвийн орлогыг маш өндрөөр шахуу төлөвлөсөн, гэтэл дэлхийн зах зээл дээр манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ буурах эрсдэл ч байна. Төсвийн орлогын алдагдлыг нөхөх хүчин чармайлт бэрхшээлтэй тулгарч болзошгүй тул төсвийн нийт зардлыг 500 тэрбумаас нэг их наяд төгрөгөөс доошгүйгээр бууруулах тооцоог олон хувилбараар хийж, нөхцөл байдалд нийцүүлэн уян хатан ажиллах шаардлага үүсэж байгааг хүлээн зөвшөөрөх.
- (д) Дотоодын бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид, хэрэглэгчид, худалдан борлуулагчдыг хамруулсан, харилцан уялдуулсан сүлжээнд оролцогчдыг санхүүжүүлэх нэгдсэн механизмыг бий болгож гадаад, дотоодын албан ёсны эх үүсвэр татах талаар хөтөлбөр, арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх. Ялангуяа цахилгаан станц, төмөр замын төслүүдийг гадаадын албан ёсны эх үүсвэрийн санхүүжилтийн оролцоотойгоор өөрсдийн хүчээр гүйцэтгэх.
- (е) Төрийн худалдан авалтаар дотоодын үйлдвэрлэлийг шууд дэмжиж, аливаа саад тотгорыг бүрэн арилгахыг санал болгож байна.

Дээр дурдсан саналуудыг зөвлөмж болгон хүргүүлэхийн зэрэгцээ яаралтай авч хэрэгжүүлэх ажлын саналыг мөн хүргүүлсэн юм. Үүнд:

- (а) 2020 онд шинээр эхлэхээр төлөвлөсөн үйлдвэрлэлийн бус хөрөнгө оруулалтыг (эхлээгүй, зураг төсөвгүй, тендерээ дүгнээгүй, тоног төхөөрөмж авах гэх мэт) зогсоож, дараа онд шилжүүлэх;
- (б) Коронавирустэй холбогдсон зардал өсөх нь тодорхой учраас захиргааны зардлыг бууруулах арга хэмжээ авах;

- (в) Энэ оны 9 дүгээр сарын 01 хүртэл аливаа байгууллагын данснаас данс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр элдэв суутгал, татан авалт, дайчлалт хийхгүй, данс хаахгүй байх;
- (г) Коронавирусийн тархалтаас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн салбарын чадавхыг бэхжүүлэх, нэн шаардлагатай бус төсвийн зардлыг эрүүл мэндийн салбарт чиглүүлэх, зардлыг оновчтой хуваарилах талаар арга хэмжээ авах;
- (д) Эмзэг бүлгийн иргэдийг коронавирүсээс хамгаалах арга хэмжээнд зориулан хөрөнгө гаргахыг нийт засаг захиргааны нэгжүүдэд үүрэг болгох;
- (е) Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, санхүүгийн салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулахгүй байх;
- (ё) Зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, бүтцийн өөрчлөлт хийх, зээлийн тасалдал үүсэхээс сэргийлж зарим зохицуулалтын арга хэмжээг түдгэлзүүлэх боломжийг судалж, шийдвэрлэх;
- (ж) Улс хоорондын үүргийн худалдааг тодорхой хугацаагаар зогсоож, гэрээт худалдаанд бүрэн шилжих гэх мэт тодорхой санал, зөвлөмж гаргасан.

2 Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлтийг хавсаргав (*Хавсралт №2*). Энэхүү санал, дүгнэлтээс зарим чухал гэсэн зүйлсийг түүвэрлэн танилцуулья.

Хавсралт №2 (29-39 хуудас)
Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн санал, дүгнэлт, зөвлөмж.

Нэг. Дүгнэлтүүд:

- Цар тахлын нөлөөгөөр буй болсон төсвийн алдагдлыг ирэх онд бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах, халамжаас ажлын байрыг урьтал болгож, иргэдийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар төсөв, сангийн бодлогыг хэрэгжүүлэхээр байгааг дэмжиж байна.
- Малын тоо, бэлчээр, байгаль орчны доройтол, малчдын хэрэгцээ зэрэг нь малыг дээд хэмжээнд хүртэл тавааржуулах ажлыг бүх талаар, түүний дотор төсөв, мөнгөний бодлогоор дэмжих шаардлага үүссэн байна.
- Монгол Улс сүүлийн жилүүдэд төсвийн сахилга батыг сайжруулан төсвийн алдагдал, өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн мөчлөг сөрсөн мөнгө, төсвийн бодлого явуулж, татварын болон төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлснээр мөнгө, санхүүгийн тодорхой нөөцийг 2020 оны эхэнд бүрдүүлсэн юм. Энэ нь 2020 оны эхнээс дэлхий дахинаа дэгдсэн Ковид-19 цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийг дэмжих, эдийн засгийг идэвхжүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг олгожээ.
- Нийт зээл дотор шууд хөрөнгө оруулалтад тооцогддог гадаадын компани хоорондын зээлийг оролцуулбал гадаадын компаниудын нийт хөрөнгө оруулалт 2019 оны эцсээр 22.55 тэрбум ам.доллар болжээ. Сүүлийн жилүүдэд уул уурхайгаас өөр салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт бараг хийгдэхгүй байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалт эдийн засгийн аль салбарт түлхүү орсныг судалж, бодлого, стратегиа

“Эдийн засгийн өсөлтийг хангах бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтцийн томоохон төслүүдийн хэрэгжилтийг хангах, халамжаас ажлын байрыг урьтал болгож, иргэдийн мөнгөн орлогыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар төсөв, сангийн бодлогыг хэрэгжүүлэхээр байгааг дэмжиж байна”.

боловсруулах боломжтой. Нийт гадаадын хөрөнгө оруулалтын 77.6 хувь буюу 17.1 тэрбум ам.доллар нь уул уурхайн салбарт ногдож байна. Өрийг төлөх эх үүсвэрийг бүрдүүлэх нь чухал юм. Иймээс дунд, урт хугацаанд валютын нөөц нэмэгдүүлэх, валютын хэмнэлт үүсгэх ач холбогдолтой, төлбөрийн болон төсвийн тэнцлийг сайжруулахад чухал нөлөөтэй төсөл, хөтөлбөрүүдийг төрийн мөнгө зээл, төсвийн бодлогоор дэмжиж, өр төлөх боломж бүрдүүлэх нь стратегийн зорилт болно.

- Гадаад зээлийн процесс, үйл ажиллагаа, бодлогод зарчмын өөрчлөлт хийж, цаашдаа аливаа арилжааны шинжтэй зээл, бондыг Засгийн газар санаачлан гарын үсэг зурж авдаг байдлыг зогсоож, төлөгдөх эх үүсвэр нь тодорхойгүй, төсөвт дарамт үзүүлэх зээлээс татгалзахаас өөр аргагүй болж байна. Зээл ашиглаж, хэрэглэдэг байгууллагуудын урдуур орж Засгийн газар буюу Сангийн яам зээл авах явдлыг хязгаарламаар байна. Эргээд төлөгдөх эх үүсвэр бүрдүүлдэг үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан тэдэнд хариуцлагыг нь үүрүүлэн гадаадаас зээл авах журам, зарчим тогтоох шаардлага үүсэж байна.
- Халамжийн тэтгэвэр, тэтгэмж болон хүүхдийн мөнгийг 2021 оны сүүлийн хагас жилээс эхлэн цар тахлын өмнөх хэмжээнд хүртэл бууруулах бодлогыг хэрэгжүүлэхгүй бол төсөв, төрийн сан, банкны системээ эрсдэлд оруулах магадлал өндөр байна. Хүүхдийн мөнгөнд сар бүр ойролцоогоор 120.0 тэрбум төгрөг өгч байна. Энэ мөнгөөр хамгийн орчин үеийн 10 үйлдвэр барьж Монгол Улс нэмүү өртөг шингэсэн, дэвшилтэт технологид тулгуурлан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд гаргах боломжтой юм”.

“Хүүхдийн мөнгөнд сар бүр ойролцоогоор 120.0 тэрбум төгрөг өгч байна. Энэ мөнгөөр хамгийн орчин үеийн 10 үйлдвэр барьж Монгол Улс нэмүү өртөг шингэсэн, дэвшилтэт технологид тулгуурлан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд гаргах боломжтой юм”.

Хоёр. Зөвлөмжийн хэсгээс:

- 2021-2023 онд Монгол Улсын эдийн засаг 6.0 хувиар өсөхөөр төсөөлжээ. Гадаад худалдааны эргэлт нэмэгдэж 2021-2023 онд гадаад худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөлд тусгагдсан байна. Үүний үр дүнд бий болсон хуримтлалыг зөв зүйтэй зарцуулах нь Засгийн газрын анхаарлын төвд байх ёстой. Тухайлбал, Өмнийн говийн төмөр замын болон цахилгаан эрчим хүчний төслийг амжилттай хэрэгжүүлбэл жилдээ хамгийн багадаа 300-400 сая ам.долларын валютын хэмнэлт үүсэж, энэ хэмжээгээр эдийн засаг, санхүү төсөвт эерэг нөлөө үзүүлнэ. Нөгөө талд төлбөрийн урсгал тэнцэл алдагдалтай байгаа нь их хэмжээний гадаад зээлийн үндсэн өр, хүүгийн төлбөртэй, маш олон төрлийн зөвлөх үйлчилгээ авдагтай, тээвэр, шатахууны зардал өндөртэй, түүнчлэн гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг дотоодын ажил үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлд шингээх чадвар, хүчин чармайлт хангалтгүй байгаатай холбоотой байна.

“Өмнийн говийн төмөр замын болон цахилгаан эрчим хүчний төслийг амжилттай хэрэгжүүлбэл жилдээ хамгийн багадаа 300-400 сая ам.долларын валютын хэмнэлт үүсэж, энэ хэмжээгээр эдийн засаг, санхүү төсөвт эерэг нөлөө үзүүлнэ”.

Төсөв, мөнгөний бодлогыг тодорхойлж эрэмбэлэхэд эхний ээлжинд экспорт, төлбөрийн тэнцлийг сайжруулахад анхаардаг олон улсын шилдэг туршлагыг авч хэрэглэх саналыг дэвшүүлж байна. Манай орны хувьд баялаг нөөцтэй зэс, нүүрс, сэргээгдэх эрчим хүчний валютын үр ашгийг нэмэгдүүлэх зарчмын ач холбогдолтой билээ. Зэсийн зах зээлийн үнэ одоохондоо өндөр, ирээдүйд зэсийн эрэлт нэмэгдэх төлөвтэй байна. Энэ нөхцөлд манайд зэсийн хайгуул, ашиглалт үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх боломж байгаа тул тэргүүн ээлжийн бодлого

“Монгол Улс Энэтхэгт нүүрс гаргах бодлого, тээвэрлэлтийн арга замыг цаг алдалгүй хэрэгжүүлмээр байна”.

болгож хөрөнгө зарцуулах чиглэл болгомоор байна. Нүүрсний тухайд байгаль орчны нөлөөгөөр цаашдаа нүүрсний хэрэглээг хязгаарлах боловч 2050 он хүртэл нүүрс хэрэглэсээр байхаар байна. Манайх шиг нүүрсний ихээхэн нөөцтэй улс үүнийгээ боломжит хэмжээгээр ашиглах нь чухал. Манай Улсын нүүрсийг Хятад, Энэтхэг, Солонгос, Япон зэрэг олон орон худалдан авах сонирхол, хэрэгцээ бий. 1.2 тэрбум хүн амаа бүгдийг нь гэрэл, дулаанаар хангахаа амласан Энэтхэгийн Ерөнхий сайдын амлалтыг хэрэгжүүлэхэд Монголын нүүрс хэрэгтэй болно. Австрали, Хятад зэрэг улсууд Энэтхэгт нүүрсээ гаргах бэлтгэлээ базааж, экспортолж эхлээд байна. Монгол Улс Энэтхэгт нүүрс гаргах бодлого, тээвэрлэлтийн арга замыг цаг алдалгүй хэрэгжүүлмээр байна.

Монгол шиг салхи, нар, газрын хөрсний дулаан, зэрэг сэргээгдэх эрчим хүчний нөөц ихтэй орон нүүрсний нүүрсний ашиглалт саармагжиж байгаа үед энэ нөөцөө ашиглах сайхан боломж байна. Япон, Өмнөд Солонгос зэрэг орнууд манай эрчим хүчийг авах сонирхолтойгоор барахгүй Монгол, Өмнөд Солонгос, Япон, Хятадын мэргэжилтнүүд хамтран боловсруулсан Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй Монголын сэргээгдэх эрчим хүч ашиглах төслийг цаг алдалгүйгээр идэвхитэй хэрэгжүүлэхэд онцгой анхаармаар байна.

“Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг зөрчсөн шийдвэр гаргавал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс вето-хориг тавьдаг, эсвэл Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх зүйн боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй”.

- Цаашид төсвийн зарлагын өсөлтийг хязгаарласан тохируулгыг “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-д оруулах, ялангуяа сонгуулийн мөчлөгийн нөлөөг бууруулах тогтолцоог уг хуульд нэмж тусгах. Тухайлбал, санхүү, банк зэрэг мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр УИХ болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг дээд шатны байгууллагаас төсөв, зээл, төлбөрийн байдалд нөлөөлөх шийдвэрийг гаргахгүй байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай. Хууль зөрчсөн шийдвэр гаргавал Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс вето-хориг тавьдаг, эсвэл Үндсэн хуулийн Цэцэд хандах эрх зүйн боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх хэрэгтэй. Мөн төсвийн алдагдлыг гэнэтхэн 10-аад хувь нэгжээр нэмэгдүүлэх бус 2-3 нэгж хувиас хэтрүүлэхгүйгээр нэмэх хязгаарлалт тогтоох нь зүйтэй байна.
- Төсөв, сангийн бодлогод зориуд анхаарч судлууштай зүйл бол цалин, хөдөлмөрийн эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж, даатгал, татвар төлдөггүй хөдөлмөр эрхлэлтийг албан ёсны болгох замаар ажил эрхлэгчдийн ирээдүйн нийгмийн баталгааг хангах явдал нэн чухал болно. Орон нутгийн бие даасан байдлыг бэхжүүлэх бодлогын хүрээнд аймаг сум, хот дүүргийн төлөөллийн болон захиргааны байгууллагын зүгээс оршин суугчдын ажил эрхлэлтийг дэмжих санал санаачилга, хариуцлагыг цалин хөлсний бодлого, стратеги, төсөв хоорондын шинэчлэлээр дамжуулан нэмэгдүүлэх нь зүйтэй.
- Нэмүү өртгийн сүлжээ бий болгох тал дээр мал, махны бэлтгэлийг дагаж мөн арьс бэлтгэх асуудал яригддаг. Малаас гарах үндсэн түүхий эд болох 400 гаруй мянган тонн мах, 30 гаруй мянган тонн хонины ноос, 10-аад мянган тонн ямааны ноолуур, 15-аас доошгүй сая ширхэг арьс, ширний нөөц байна. Эдгээрийг цуглуулж эргэлтэд оруулна гэвэл ойролцоогоор 3 их наяд гаруй төгрөг буюу 1.1 тэрбум ам.доллар гарах юм. Мал аж ахуйн зарим түүхий эдийг бэлтгэж, боловсруулж, экспортод гаргахад зориулж 500.0 орчим тэрбум төгрөгийн зээлд 5 хувь нэгж

хүүний хөнгөлөлтийг улсаас олгохыг санал болгож байна. Үүнд 25.0 орчим тэрбум төгрөг шаардагдана. Арилжааны банкууд Монгол Улсын Хөгжлийн банкттай хамтран 13 хувийн хүү (бодлогын хүү 10 хувь, банкны зардлаа нөхөх хүү 3 хувь)-тэйгээр дурдсан зориулалтаар экспортлогч аж ахуйн нэгжид олгож, хэрэгжилтийг хангаж чадвал, үйлдвэрүүдэд зээлийн хүүний зөрүү 5 хувийг төсвөөс Хөгжлийн банкаар дамжуулан олгох хувилбар байж болох юм.

- Монгол Улс мал аж ахуйн түүхий эдийн 20 хүрэхгүй хувийг өөрсдөө бэлтгэж дотоод болон гадаад зах зээлд нийлүүлдэг. Энэ хувь хэмжээг цаашид нэмэгдүүлэх, Монгол Улсын хүн амын 1/3 болсон малчид, тэдгээрээс хамаарал бүхий иргэдийн орлогыг багасгахгүй байлгах явдал тулгамдсан зорилтын нэг юм. Үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгө дутмаг, хүчин чадлаа бүрэн ашиглах хэмжээнд улирлын чанартай түүхий эдээ өндөр хүүтэй арилжааны зээлээр хангах нь тэдэнд туйлын эрсдэлтэй хэвээр байна. Нөгөө талаар Европ, Америк, Азийн ихэнх зах зээл удаан хугацаанд хаагдсан үед үйлдвэрлэл нэмэгдээд ч борлуулалт хязгаарлагдмал болно. Тухайлбал, ноолууран бүтээгдэхүүний томоохон зах зээлүүд түр хаагдсан байгаа. Тиймээс үйлдвэрлэлийг төдийлөн их биш зохистой түвшинд хадгалах, зээлийн эргэн төлөлт нь санхүүгийн эргэлтийн хөрөнгийн хүндрэлийг нэмэх тул зээлийн төлөлтийн хугацааг хойшлуулах нь илүү зохистой дэмжлэг байх болно.
- Хоёр хөрш болон бусад орнуудтай хийх худалдааг эрчимжүүлэх, чөлөөтэй болгох арга замыг холбогдох талуудтай хэлэлцэж нэн яаралтай шийдвэрлүүлэх, ялангуяа нүүрсний худалдааг нэмэгдүүлэх арга замыг тохиролцох хэрэгтэй.
- Төрөөс гадаад, дотоод эх үүсвэртэй зээлийн болон батлан даалтын сангуудын зарцуулалтыг дэмжихдээ экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох салбарын санхүүжилтэд чиглүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.



2.3. Цаг үеийн зарим асуудлын талаар:

1. УИХ, УИХ-ын Төсвийн байнгын хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлэг, семинар зөвлөгөөнд 4 удаа оролцож, үг хэлж санал бодлоо илэрхийлж ирлээ.
2. УИХ, Дэлхийн банкнаас 2020 оны 10 дугаар сарын 5-нд хамтран зохион байгуулсан “Уул уурхай ба Оюун ухаан” сэдэвт хэлэлцүүлэг, түүнд зориулан боловсруулсан илтгэл, холбогдох хүмүүсийн хэлсэн үгэнд төсөв, сангийн бодлого, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажилд ихээхэн ач холбогдол өгч, санал дүгнэлтээ илэрхийлсэн билээ. Дэлхийн банкнаас боловсруулж тараасан “Уул уурхай ба Оюун ухаан” нэртэй тайлан-илтгэлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн төсвийн алдагдал, өрийг хязгаарлах зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг хатуу мөрдөж ажиллаж, санхүүгийн нөөц бүрдүүлэх, Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийн бие даасан, мэргэжлийн байх эрх зүй, зохион байгуулалтын орчныг боловсронгуй болгох, ажлын албыг нь бэхжүүлж, мэргэшүүлэх чадамжийг бэхжүүлэх тодорхой санал дүгнэлт, зарим орны сайн туршлагыг оруулан мэдээлсэн. Энэхүү тайлан илтгэлээс холбогдох хэсгийг хавсралтаар танилцуулж байна (Хавсралт №3). Энэхүү хавсралтаас төр, засгийн төсвийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс судалгаа дүгнэлт хийж, төсвийн дүрэм, сахилгыг мөрдүүлэхэд дэмжлэг

Хавсралт №3 (40-41 хуудас)

Уул уурхай ба Оюун ухаан” илтгэл-тайланд ТТБЗ-тэй холбогдох хэсэг.

үзүүлдэг байгууллагын чадавх, санаачилгыг ашиглах нь төсөв, санхүү, улмаар эдийн засгийг эрүүлжүүлэхэд чухал ач хобогдолтой болохыг харж болно.

УИХ-ын дарга тус хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ ТТБЗ-ийн үйл ажиллагааг дэмжиж, туслалцаа үзүүлэхээ илэрхийлсэн бол хэлэлцүүлгийг зохион байгуулж даргалж байсан УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга Дэлхийн банкны санал, зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдэж, ТТБЗ-ийн даргад мэдээлэл хийх боломж олгосон юм. Эхний ээлжинд төсвийн дүрэм, хуулийн хязгаарлалтыг мөрдөж ажиллахын ач холбогдол, энэ талаарх нэгдсэн ойлголтыг нийгмийн бүх давхаргад бий болгох, төсөв, санхүүгийн шийдвэрийг мэргэжлийн байгууллагын санал дүгнэлт, судалгаанд үндэслэн гаргахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ТТБЗ санаачилга гарган ажиллаж байна гэдгээ мэдээлсэн болно.

“2020 оны хувьд нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 10 гаруй хувийг давах, өрийн дарамт улам бүр нэмэгдэж, үндэсний орлогынхоо дөрөвний нэг буюу 3.2 тэрбум ам.долларыг зээлийн үйлчилгээний төлбөрт зориулах урьдчилсан гүйцэтгэл гарлаа”.

3. УИХ-ын Төсвийн байнгын хорооноос төсвийн харилцааны асуудлаар 2020 оны 9 дүгээр сарын 20-нд зохион байгуулсан УИХ-ын зарим гишүүд, яам, газар, эрдэм шинжилгээний байгууллагуудын удирдах ажилтнууд, судлаачид оролцсон семинарт ТТБЗ-ийн дарга “Төсвийн тогтвортой байдлыг урт, дунд, богино хугацаанд хангахад анхаарах асуудал”-аар илтгэл тавьж, хэлэлцүүлэгт оролцсон. 2020 оны хувьд нэгдсэн төсвийн алдагдал ДНБ-ий 10 гаруй хувийг давах, өрийн дарамт улам бүр нэмэгдэж, үндэсний орлогынхоо дөрөвний нэг буюу 3.2 тэрбум ам.долларыг зээлийн үйлчилгээний төлбөрт зориулах урьдчилсан гүйцэтгэл гарлаа. Зээлээ багасгаж, дунд хугацаанд өрөө барагдуулбал жилдээ 3 тэрбум ам.доллар гадагш төлөхгүй болж, эх орон маань хөгжлийн манлайд хүрнэ. Өрийн занганаас гарах нь стратеги зорилт мөн. Олон улсын санхүүгийн зах зээлээс босгосон бондуудын үндсэн төлбөр ойрын жилүүдэд төлөгдөх хуваарьтай, эдгээр бондууд-үнэт цаасны хүүд нь жилдээ 600 сая орчим ам.доллар төлөхөөр харагдаж байгаа. Эдгээр бондыг шинэ бондоор солихгүйн төлөө зүтгэцгээх нь хөгжлийн гарц мөн. Иймээс төсвийн тогтвортой байдлыг хангахын тулд Монгол Улсын зээлийн зэрэглэлийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг багасгах, өрийг бууруулах, валютын нөөцийг нэмэгдүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй болжээ гэсэн дүгнэлтийг танилцуулсан юм.
4. ТТБЗ-ийн гишүүн Л.Отгонтуяа “Монгол Улсад хэрэгжүүлж буй төсвийн зарлагын удирдлагын шинэчлэл, туршлага, сорилт” судалгааны үр дүнг ТТБЗ-ийн гишүүдэд болон ТБХ-ноос зохион байгуулсан хуралд танилцуулснаас гадна Төсвийн тогтвортой байдлын чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХ-ын Төлөөлөгчдөд хийсэн сургалтын явцад, мөн төрийн албан хаагчдад зориулан явуулж буй сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний явцад мэдээлж, танилцуулжээ.
5. ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуу, гишүүн Э.Бямбажав, Ё.Мөнхбаатар, ажлын албаны ажилтнууд Завхан аймгийн Улиастай, Дөрвөлжин, Алдархаан сумдад томилолтоор ажилласан. Томилолтын хугацаанд сумдын иргэд, бизнесийн төлөөлөл болох 30 гаруй иргэдээс татвар, төсөв, бизнес эрхлэлт, ажлын байрны чиглэлээр тусгай асуулга гаргаж, хариулт авч, ажил хэрэгтээ ашиглаж байна. Томилолтоор ажилласан баг тус аймаг, сумын эдийн засаг, төсвийн байдалтай танилцаж, ТТБЗ-ийн үйл ажиллагааг сурталчилж, аймаг, сумын удирдлага, ажилтнуудтай уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, мэдээлэл солилцсон болно.
6. ТТБЗ-ийн гишүүн Д.Сувдаа “Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангах нь” сэдвээр, Г.Алтанзаяа “Татварын боловсрол төсвийн

тогтвортой байдалд нөлөөлөх нь” сэдвээр судалгааны ажлыг удирдаж эхлүүлээд байна.

7. Монгол Улсын төлбөрийн тэнцэл, гадаадын хөрөнгө оруулалтын байдал, гадаад өр, түүний дотор монгол төгрөг, Хятадын юаний своп хэлцлийн өглөг зэргийн талаар судалгаа хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулсан. Төгрөг, юанийн солилцооны дүнгээр үүссэн өглөг, түүний хүүгийн талаар хийсэн судалгааг холбогдох саналын хамт Засгийн газрын шадар сайд, ТБХ-ны дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчид албан бичгээр хүргүүлсэн болно. Жил бүр Хятадын талд төлж буй 400-аад тэрбум төгрөгтэй тэнцэх юань нь Монголбанкны хуримтлагдсан алдагдлыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцэлд сөрөг нөлөө үзүүлж, яваандаа татвар төлөгчдөд дарамт үзүүлэх эрсдэлтэй гэдгийг холбогдох удирдлагын анхааралд оруулах, өглөгийг шийдэх арга замын талаар олон хувилбарт саналыг дээрх танилцуулга, бичигт дурдсан. Цаашдаа өөрсдийн боловсруулсан санал, судалгааг ажил хэрэг болгохын төлөө хичээн ажиллаж байна.
8. Монгол Улсын төсөв, макро эдийн засгийн тоо, мэдээлэл, тайлантай тогтмол танилцаж ажлын хэрэгцээндээ ашиглан тогтворгүй байдлыг үүсгэж болох гол хүчин зүйлсийг судалж байна. Тухайлбал, төсвийн орлогод голлон нөлөөлдөг нефтийн бүтээгдэхүүн, нүүрс, зэс, алтны үнийн өсөлт, бууралтыг ажиглаж, зохих мэдээлэл цуглуулж, ажил хэрэгтэй ашиглаж, санал дүгнэлтээ УИХ-ын зарим гишүүд, байнгын хорооны дарга, холбогдох хурал зөвлөгөөнд танилцуулж ирсэн.
9. УИХ-ын Тамгын газрын Төсвийн шинжилгээний албанаас гаргадаг Монгол Улсын нэгдсэн төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ, танилцуулгыг ТТБЗ хүлээн авч, санал дүгнэлт гаргахдаа тогтмол ашиглаж байна. Манай зөвлөлийн гол анхаарч байгаа зүйл бол экспортын үйлдвэрлэл гадаад худалдааны статистик хэр зэрэг байгаа талаар, Монгол Улсын экспортын 90 гаруй хувь нь эрдэс түүхий эдийн бүтээгдэхүүнээс хамаардаг учраас тэдгээрийн зах зээлийн байдал, цаашид Монгол Улсын бодлогыг тодорхойлох шаардлагатай байгаа газрын тос, эрчим хүчний импортыг багасгах бодлого, чиглэлийг нийтэд мэдээлж, анхаарлын төвд оруулахыг хичээж ирлээ. Бодлого боловсруулагчид эн тэргүүнд өөрийн дотоодын эх үүсвэрийг ашиглаж импортоор авч байгаа бүх төрлийн газрын тосны бүтээгдэхүүн болон эрчим хүчний бүтээгдэхүүнийг авахгүй байх нөхцөл бүрдүүлэхийн чухлыг онцлон гаргахыг хичээж ирлээ.



ГУРАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА

1. Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр Дэлхийн банктай хамтран төсөл хэрэгжүүлж зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх, мэргэжилтэн сургах, программ хангамж худалдан авах зэрэг арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхээр харилцан тохиролцоод ажиллаж байна.
2. Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төслийн хүрээнд Дэлхийн банкнаас Төсвийн тогтвортой байдлын Зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэн тогтмолжуулахад дэмжлэг үзүүлэх зөвлөмж бичгийг Дэлхийн банкнаас 2020 онд ирүүлсэн болно. Энэхүү бичигт улс орнуудад ажилладаг төсвийн бие даасан зөвлөлийн ач холбогдол, эрхлэх ажил үүрэг, бүтэц зохион байгуулалт, оролцогч талуудтай хэрхэн харилцах талаарх олон улсын шилдэг туршлага, Монголын ТТБЗ-ийн өнөөгийн байдал, цаашид сайжруулах замын зураг, үзүүлэх

Хавсралт №4 (42-64 хуудас)

ТТБЗ-ийн үйл ажиллагааг идэвхижүүлэн тогтмолжуулахад дэмжлэг үзүүлэх Дэлхийн банкны зөвлөмж бичиг.

“ТТБЗ-ээс макро эдийн засгийн болон төсвийн дунд хугацааны үзүүлэлт боловсруулах загварчлал гаргах, Тооцоолол, төсөөлөл хийдэг программ хангамж, мэдээллийн технологид суурилсан нэгдсэн систем (дашбоард, анализ, танилцуулга, интерактив) хөгжүүлж нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авч байна”.

Хавсралт №5 (65-66 хуудас)

Санхүүгийн зохицуулах хороотой байгуулах санамж бичгийн төсөл.

зөвлөх үйлчилгээний хүрээ, нэр төрөл, шинжилгээ судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулах чадавхыг бэхжүүлэх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг тусгасан. Энэхүү зөвлөмжийг хавсаргав (Хавсралт №4).

3. ТТБЗ-ийн Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавруудыг (ToR) боловсруулж Дэлхийн банкны саналыг тусган төсөл хэрэгжүүлэх шатандаа явж байна. Дараах чиглэлээр зөвлөх үйлчилгээ авна. Үүнд:
 - Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд зориулсан үйл ажиллагааны зааврыг тодорхой тайлбарласан үйл ажиллагааны гарын авлага буюу түүнтэй ижил төстэй баримт бичгийг олон улсын шилдэг стандартад нийцүүлэн боловсруулах зөвлөх үйлчилгээ
 - Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс макро эдийн засгийн болон төсвийн дунд хугацааны үзүүлэлт боловсруулах загварчлал гаргах, Тооцоолол, төсөөлөл хийдэг программ хангамж, мэдээллийн технологид суурилсан нэгдсэн систем (дашбоард, анализ, танилцуулга, интерактив) хөгжүүлж нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ хамаарна.
4. Зөвлөл, Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд бусад улс орны туршлага, судалгааны үр дүнг үндэслэн төсвийн зөвлөлийн стратеги төлөвлөгөө боловсруулах, зөвлөлийг бэхжүүлэх, хөгжүүлэх баримт бичгийн төсөл боловсруулахаар Зөвлөх үйлчилгээ зарлан зөвлөхийг сонгон шалгаруулахаар ажиллаж байна.
5. Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжлийн газруудаас эрхлэн гаргадаг тоон мэдээллийг олон нийтэд түгээдэг (веб хуудас) хэлбэрээр танилцаж байна. Цаашдаа илүү нарийвчилсан мэдээлэл авах үүднээс дээрх байгууллагуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох санамж бичгийн төслийг боловсруулан хүргүүлээд байна (Хавсралт №5. Санамж бичгийн төсөл).
6. Мөн тайлант үед УИХ-ын Тамгын газар, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Монголбанк, Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх төсөл, Үндэсний Статистикийн хороогэх мэт байгууллагуудруу 40 албан бичиг явуулж харилцсан.

ДӨРӨВ. ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

Олон нийтийн хэвлэл мэдээлэл, өдөр тутмын сонин, вебсайтууд, телевиз, судалгааны байгууллага, судлаачидтай хамтран ажиллаж байна. Зөвлөлөөс гарсан санал, дүгнэлт, зөвлөмжүүдийг тухай бүр УИХ-ын цахим хуудас буюу www.parliament.mn сайтад байршуулан ажиллаж байна. Эдгээрээс зарим мэдээлэл нийтийн вэбсайтуудад тавигдаж, олон түмэнд хүртээл болж байна. Мөн Монголбанкны вэбсайтэд ТТБЗ-ийн зарим гишүүдийн ярилцлага хэвлэгдсэн.

Төсөв, ТТБЗ-ийн үйл ажиллаганы талаар гарсан судалгааны материал, шүүмжлэл зэргийг тогтмол хүлээн авч, тэдний зохиогчидтой харилцаж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд ТТБЗ-ийн гишүүдээс дараах нийтлэл ярилцлагыг хэвлүүлжээ.

- Өдрийн сонин 2020 оны 5 дугаар сарын 11-ний дугаарт ТТБЗ-ийн гишүүн Э.Бямбажав хямралын үеийн эдийн засгийн байдал, төсвөөс авах арга хэмжээний талаар дэлгэрэнгүй ярилцлага гаргасан.
- 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Зөвлөлийн дарга Д.Даваасамбуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа, төсвийн дүрэм, шалгуур, Монгол Улсын 2021 оны Нэгдсэн төсвийн төсөлд өгсөн



санал, зөвлөмжийн талаар Өдрийн сонинд ярилцлага өгсөн.

- 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Зөвлөлийн хараат бус гишүүн Г.Алтанзаяа “Татварын боловсрол Төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь” сэдвээр өдрийн сонинд ярилцлага өгсөн.
- ТТБЗ-ийн дарга Д.Даваасамбуу Блүүмберг, ТВ-9 телевиз, зөвлөлийн гишүүн Л.Отгонтуяа Ийгл телевизэд ярилцлага өгч, гишүүн Э.Бямбажав, Б.Энхжин, Г.Алтанзаяа нар нийтлэл хэвлүүлж, мэдээлэл сурталчилгаа хийлээ.

ТАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА



ТТБЗ дотоод үйл ажиллагаандаа УИХ, түүний ТБХ-аас баталсан дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Энэхүү эрх зүйн хэм хэмжээгээр хүлээлгэсэн ажил үүргээ жилээр төлөвлөж, түүний хэрэгжилтийг ТТБЗ-ийн ажлын алба, ТБХ-ны ажилтнууд, УИХ-ын Тамгын газар, түүний төсвийн шинжилгээний албаны дэмжлэгтэйгээр хангаж ажиллаж байна.

ТТБЗ-ийн гишүүдийн ажлын тайлан, мэдээллийг тогтмол авч, холбогдох газруудад танилцуулж байна. ТТБЗ-ийн дүгнэлт, санал зөвлөмжийг ТБХ, шаардлагатай үед УИХ-ын дарга, Тамгын газарт тогтмол хүргүүлж байна. Тайлант жилд улс орны төсөв, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, Ковид-19 цар тахал дэгдсэн болон төв, орон нутгийн сонгуулийн үйл ажиллагаатай холбогдуулан цаг үеийн асуудлыг тухай бүр хэлэлцэж, санал дүгнэлтээ гарган ажилласан.

Тайлант хугацаанд нийт 6 удаа хурал хийж, дараах асуудлуудыг хэлэлцсэн. Зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан, 2020 оны төлөвлөгөө, төсөв, Цар тахлын үед эдийн засаг, төсвийн талаар авах арга хэмжээ, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдэд хийсэн дүгнэлт, санал зөвлөмж зэрэг бүрэн эрхт хамааралтай асуудлууд байна.

Түүнээс гадна ТТБЗ, Дэлхийн банкны хамтын ажиллагаа, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, удирдамж, макро-эдийн засгийн байдал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт, гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл, бондын өр, төгрөг, юаний своп хэлцлийн байдал, зарим томоохон компаниудын санхүүгийн байдал, зэс, нүүрс, газрын тос, алтны дэлхийн зах зээлийн үнийн түвшин, Сангийн яам, Монголбанк болон бусад холбогдох байгууллагуудтай байгуулсан болон байгуулах санамж бичиг зэргийг хянаж шинэчлэх ажлыг зохион байгуулав.

Сүүлийн үед ТТБЗ-ийн хуралдаан, гишүүдийн ярилцлагыг Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас онлайн хэлбэрээр Zoom апп ашиглан зохион байгуулж байна.

ТТБЗ-ийн үйл ажиллагааг ил тод болгох, эрчимжүүлэх, ажлын алба, төсвийн шинжилгээний ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхэд онцгой анхааран ажиллаж, зарим эхлэлийг тавиад байна. Зарим хийгдсэн зүйлээс дурдвал:

1. Зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах эрхзүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр УИХ-ын Дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлж

байх"-аар тусгаж хуульд оруулах санал өгсөн боловч тусгагдаагүй болно. Цаашид Дэлхийн банкнаас хэрэгжиж буй төслийн хүрээнд эрх зүйн орчныг нарийвчлан авч үзэж Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль болон бусад хууль тогтоомжид Зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг зайлшгүй хэлэлцэх, хэлэлцээгүй тохиодолд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай тусгах боломжийг эрэлхийлэн ажиллах болно. Одоогоор УИХ нь Зөвлөлөөс гарсан санал, зөвлөмжийг хүлээн авах сонирхол бага, эрхзүйн талаас боломжгүй байна.

2. Зөвлөлийн өмнөх жилүүдийн төсвийн ангилал оновчтой биш байсанд дүгнэлт хийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 2021 оны төсвийн хязгаарын саналыг боловсруулан УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн.

3. Зөвлөлийн гишүүд хийсэн ажлынхаа тайланг сар бүр гарган нэгтгэж УИХ-ын Тамгын газарт хүргүүлж байна.

4. Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хамтран "Монгол Улсын Үндсэн хуульд төсвийн чиглэлээр оруулсан өөрчлөлт ба төсвийн төлөвлөлтийн цаашдын хандлага" сэдэвт хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн ордны Их эзэн Чингис хаан танхимд зохион байгуулав. Уг хэлэлцүүлэг Төрийн захиргааны байгууллагууд, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд, эрдэмтэн судлаачид нийт 80 орчим оролцогчидтой болов.



5. Төсвийн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүн сонгон шалгаруулж, Удирдлагын академийн багш Л.Отгонтуяаг Зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгов.

6. 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Төсвийн байнгын хорооны хуралдаанаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн эхний хагас жилийн тайланг хэлэлцүүлэв.

7. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хөндлөнгийн хараат бус, мэргэжлийн төрийн бус байгууллага, судлаачаар судалгаа, шинжилгээний ажилгүйцэтгүүлэх ажлын хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр судалгааны байгууллага, судлаачтай доорх сэдвийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийлгэхээр гэрээ байгуулсан.

- "Татварын боловсрол төсвийн тогтвортой байдалд нөлөөлөх нь" судалгааны гэрээ
- "Орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангах нь" судалгааны гэрээ

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн 2020 оны ажлын тайланг та бүхэнд танилцууллаа.

Бидний тайлантай танилцаж үнэтэй зөвлөгөө өгнө гэдэгт та бүхэнд найдаж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлыг төрийн түшээдэд болон Улсын Их Хурал, Засгийн газрын анхаарлын төвд хүргэж ажил хэрэг болгохын тулд Зөвлөлөөс гаргах зөвлөмж, санал, дүгнэлтийг ажил хэрэг

болгох эрх зүйн үндсийг буй болгох нь зүйтэй гэж үзэж байна. Энэ талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс холбогдох хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийн төсөл боловсруулан УИХ-ын гишүүдэд танилцуулан хамтран ажиллахаар төлөвлөж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баримтлан ажиллаж Монгол Улсын нэгдсэн төсвийг тогтвортой байлгах, төсвийн алдагдлыг бууруулах, төсвийн иж бүрдлийг хангах, төсвийн гадуурх санхүүжилт гаргуулахгүй байхад анхаарч ажиллах нь нь манай эрхэм зорилт юм.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



Хавсралт хүснэгтүүд (1-7)**Хүснэгт №1:** Монгол Улсын нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

(Тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020			2021	2022	2023
	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Бат.	Тод.	Урьд.Гүйц	Төсөл	Төс.	Төс.
ДНБ-ий бодит өсөлт (хувиар)	1.2	5.3	7.3	7.0	6.0	-1.0	-1.0	7.2	4.4	6.5
Хэрэглээний үнийн индекс (хувиар)	0.1	7.7	8.6	8.0	8.0	3.8	3.8	7.0	6.0	6.0
Тэнцвэржүүлсэн орлого	5,835.00	7,274.90	9,345.10	10,095.50	11,797.80	9,730.90	9,421.65	11,797.80	11,421	12,003
ДНБ-д эзлэх хувь	24.4	26.8	29.1	29.6	29.0	25.2	25.5	27.9	25.0	24.0
Нийт зардал ба цэвэр эзэл	9,495.30	9,017.30	9,317.20	11,661.70	13,872.60	14,577.50	13,960.79	13,951.60	13,069	13,404
ДНБ-д эзлэх хувь	39.8	33.2	29.0	31.6	34.1	37.7	37.8	33.0	28.6	26.8
Төсвийн тэнцэл (тэнцвэржүүлсэн орлогоор)	-3,660.30	-1,742.50	27.9	-756.2	-2,074.70	-4,846.60	-4,539.14	-2,153.70	-1,648	-1,401
ДНБ-д эзлэх хувь	-15.3	-6.4	0.1	-2.0	-5.1	-12.5	-12.3	-5.1	-3.6	-2.8
Хөрөнгийн зардал	2,360.20	1,658.10	1,680.40	3,016.60	3,679	3,408.00	3,051.65	3,498.50	3,204	3,034
ДНБ-д эзлэх хувь	9.9	6.1	5.2	8.2	9.0	8.8	8.3	8.3	7.0	6.1
Зээлийн хүүний төлбөр	986.1	1,156.50	1,046.40	860.9	960	972.6	959.41	1,137.5		
ДНБ-д эзлэх хувь	4.1	4.3	3.3	2.3	2.4	2.5	2.6	2.7		
Өр, өнөөгийн үнэ цэнээр			18,956	20,526	22,089			26,141	25,863	26,620
ДНБ-д эзлэх хувь			58.9	55.6	54.3			61.9	56.5	53.2
Нэрлэсэн ДНБ	23,886.40	27,167.00	32,165.90	36,898.60	40,683.10	38,688.30	36,958.55	42,230.10	45,775	50,038

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №2: Нэгдсэн төсвийн 2020, 2021 оны төсвийн орлогын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	ТТО-д эзлэх хувь	Төсвийн орлогын харьцуулалт				ДНБ-д эзлэх хувь		
		2020	2021	Зөрүү, тэрбум төгрөг	Өсөлтийн хувь	2020	2021	Зөрүү
		Урьд. Гүйц	Төсөл			Урьд. Гүйц	Төсөл	
Нийт орлого ба тусламжийн дүн	100	10,401.9	13,134.0	2,732.1	26.3%	28.1	31.1	3.0
Тогтворжуулалтын сан	1.2	66.2	156.0	89.8	135.5%	0.2	0.4	0.2
Ирээдүйн өв сан	9	914.1	1,180.1	266.0	29.1%	2.5	2.8	0.3
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	89.8	9421.6	11,797.8	2,376.2	25.2%	25.5	27.9	2.4
1 Татварын орлого	91.3	8501.8	10,754.4	2,252.6	26.5%	23.0	25.5	2.5
1.1 Орлогын албан татвар	24.4	2220.5	2,885.0	664.5	29.9%	6.0	6.8	0.8
1.1.1 ХХОАТ	8.5	857.6	1,002.6	145.0	16.9%	2.3	2.4	0.1
1.1.2 ААНОАТ	16	1398.5	1,882.6	484.1	34.6%	3.8	4.5	0.7
1.2 НДШ	16.9	1588.1	1,996.7	408.6	25.7%	4.3	4.7	0.4
1.3 Хөрөнгийн албан татвар	1.5	154.5	175.7	21.2	13.7%	0.4	0.4	-
1.4 НӨАТ	23.8	2205.2	2,804.0	598.8	27.2%	6.0	6.6	0.6
1.5 Онцгой албан татвар	8	776.9	939.2	162.3	20.9%	2.1	2.2	0.1
1.6 Тусгай зориулал-тын орлого	0.2	17.1	20.0	2.9	17.2%	0.0		-
1.7 Гаалийн албан татвар	7.9	740.7	935.0	194.3	26.2%	2.0	2.2	0.2
1.8 Төлбөр, хураамж	8.5	798.8	998.7	199.9	25.0%	2.2	2.4	0.2
2 Татварын бус орлого	8.8	919.9	1,043.4	123.5	13.4%	2.5	2.5	-
2.1 Нийтлэг орлого	7.6	779.8	892.7	112.9	14.5%	2.1	2.1	-
2.2 Хөрөнгийн орлого	3.3	1.1	400.0	398.9	35923.1%	0.0	0	-
2.3 Тусламжийн орлого	1.2	139.0	150.3	11.3	8.1%	0.4	0.4	-

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №3: Монгол Улсын Нэгдсэн төсвийн зарлага

Тэрбум төгрөг

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020			2021	Зөрүү
	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Гүйц.	Бат.	Тод.	Ур.Гүйц	Төсөл	
НИЙТ ЗАРЛАГА, ЦЭВЭР ЗЭЭЛ	9,495.3	9,017.3	9,317.2	11,661.7	13,872.6	14,577.5	13,960.8	13,951.6	-9.2
УРСГАЛ ЗАРЛАГА	6,613.8	7,043.2	7,350.3	8,228.6	10,019.4	11,150.9	10,871.6	11,012.0	140.4
Бараа, үйлчилгээний зардал	3,133.3	3,141.4	3,327.5	4,000.5	4,785.5	4,958.1	4,875.5	4,440.7	-434.8
Цалин, хөлс	1,746.8	1,800.4	1,878.9	2,257.0	2,628.0	2,656.5	2,648.1	2,415.0	-233.1
Бараа, үйлчилгээний бусад зардал	1,386.5	1,341.0	1,448.6	1,743.5	2,157.5	2,301.6	2,227.4	2,025.7	-201.7
Зээлийн хүүний төлбөр	986.1	1,156.5	1,046.4	861.0	959.8	972.6	959.4	1,137.5	178.1
Татаас ба урсгал шилжүүлэг	2,494.4	2,745.3	2,976.4	3,367.1	4,274.1	5,220.2	5,036.7	5,433.7	397.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,360.2	1,658.1	1,680.4	3,016.7	3,806.1	3,408.0	3,051.7	3,498.5	446.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	521.3	316.0	286.5	416.4	47.1	18.6	37.6	-558.9	-596.5

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №4: Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

Тэрбум төгрөг

Үр дүнгийн үзүүлэлт	2019	2020	
	Гүйцэтгэл	Тодотгол	Урьдчилсан Гүйц.
ДНБ	35331.3	38688.3	36958.6
Нийт орлого ба тусламжийн дүн	12040.3	10729.3	10402.0
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	10905.5	9730.9	9421.6
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	11661.7	14577.5	13960.8
Төсвийн суурь тэнцэл	378.6	-3848.2	-3558.8
ДНБ-д эзлэх хувь	1.1	-9.9	-9.6
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-756.2	-4846.6	-4539.1
ДНБ-д эзлэх хувь	-2.0	-12.5	-12.3
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	756.2	4846.6	-4539.1
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр өөрчлөлт	-1103.4	0.0	2142.6
2. ЭГ-ын үнэт цаас	-165.1	932.7	-249.4
2.1. Урт хугацаат	-165.1	932.7	-249.4
2.1.1. Дотоод	-165.1	932.7	-263.0
2.1.1.1. Шинээр гаргах	0.0	1195.7	0.0
2.1.1.2. Үндсэн төлбөр	-165.1	-263.0	-263.0
2.1.1.3. Худалдаж авах	0.0	0.0	0.0
2.1.2. Гадаад	0.0	0.0	13.6
2.1.2.1. Шинээр гаргах	0.0	0.0	1712.7
2.1.2.2. Үндсэн төлбөр	0.0	0.0	-1699.1
3. ЭГ-ын зээл	1651.6	3311.3	2481.5
3.2. Гадаад	1185.3	3070.7	2667.5
3.2.1. Төслийн зээл	777.2	748.7	689.4
3.2.1.1. Шинээр авах	1215.5	1472.9	1380.5
3.2.1.2. Үндсэн төлбөр	-438.3	-724.2	-691.1
3.2.2. Хөтөлбөрийн зээл	408.1	2322.0	1978.1
3.2.2.1. Шинээр авах	408.1	2322.0	1978.1
4. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл		322.0	149.7
5. Өмч хувьчлал		1.0	0.3

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №5: Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн
хураангуй хүснэгт

Сая ам.доллар

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
	Жилийн	Жилийн	Жилийн	Урьд.Гүйц
I. Урсгал тэнцэл	-1,155.4	-2,206.8	-2,161.7	-576.2
Худалдааны тэнцэл	1,493.7	675.5	1,158.1	1,767.1
Экспорт	5,834.3	6,556.5	7,182.8	1,767.1
Импорт	4,340.6	5,881.0	6,024.7	5,258.3
Үйлчилгээний тэнцэл	-1,216.1	-1,978.3	-1,991.7	-1,485.9
Орлого	966.3	1,111.6	1,232.7	634.6
Зарлага	2,182.4	3,089.9	3,224.4	2,120.5
Орлогын данс	-1,433.0	-904.0	-1,328.1	-857.5
II. Хөрөнгийн тэнцэл	77.7	91.9	160.8	105.8
III. Санхүүгийн тэнцэл	-2,599.3	-2,091.0	-2,677.6	-1,388.6
1. Шууд хөрөнгө оруулалт	-1,445.7	-2,136.7	-2,316.4	-1,648.7
2. Багцын хөрөнгө оруулалт	-493.1	-60.8	-372.3	559.6
V. Нөөц хөрөнгө	1,459.9	-141.7	452.9	786.9
1. ГВУН	1,577.4	-38.1	452.9	786.9
2. ОУВС-гийн зээл	117.5	103.6	0.0	0.0
3. Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт №6: Монгол Улсын Нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	Зөрүү
	Гүйц .1.	Гүйц .2.	Гүйц .3.	Гүйц .4.	Гүйц .5.	Гүйц .6.	Гүйц .7.	Урьд-Гүйц .8.	Төсөл .9.	
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	17,560,173.3	21,937,159.4	23,166,779.1	23,886,409.5	27,167,034.7	32,165,966.4	36,897,640.2	36,958,550.1	42,230,139.8	5,271,589.7
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,986,925.2	6,316,522.6	5,983,397.7	5,835,043.8	7,958,264.6	10,172,760.3	12,040,327.3	10,401,975.6	13,134,000.0	2,732,024.4
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	46,858.6	39,913.8	2,333.7	0.0	325,680.2	206,986.6	94,596.6	66,242.9	156,016.9	89,774.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	0.0	0.0	0.0	0.0	357,722.8	620,693.6	1,040,219.9	914,085.5	1,180,143.1	266,057.6
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,940,066.7	6,276,608.8	5,981,064.0	5,835,043.8	7,274,861.6	9,345,080.1	10,905,510.8	9,421,647.2	11,797,840.0	2,376,192.8
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,164,685.3	7,144,568.0	7,137,973.9	9,495,332.9	9,017,318.6	9,317,220.8	11,661,700.9	13,960,787.5	13,951,577.2	-9,210.3
А. УРСГАЛ ЗАРЛАГА	4,552,606.6	5,293,361.6	5,718,373.8	6,613,809.1	7,043,161.7	7,350,338.9	8,228,578.8	10,871,574.4	11,012,009.4	140,435.0
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,490,741.7	1,771,069.2	1,396,704.6	2,360,210.2	1,658,140.7	1,680,430.2	3,016,672.2	3,051,655.0	3,498,476.5	446,821.5
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-224,618.7	-867,959.1	-1,156,909.8	-3,660,289.1	-1,742,456.9	27,859.3	-756,190.0	-4,539,140.3	-2,153,737.1	2,385,403.2
Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-1.3	-4.0	-5.0	-15.3	-6.4	0.1	-2.0	-0.1	-5.1	
Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн анхны нөхцөл буюу ДНБ-ий 2 хувь хүртэл алдагдалтай байх үеийн төсвийн тэнцэл	-351,003.5	-438,743.2	-463,335.6	-477,728.2	-543,340.7	-643,319.3	-737,952.8	-773,765.0	-844,602.8	

Эх сурвалж: Сангийн яам

Хүснэгт №7: МОНГОЛ УЛСАД ОРСОН ГШХО-ЫН ҮЛДЭГДЭЛ,
(Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, улирлаар)

ЭЗҮА-ны салбар	2010		2011		2012		2013		2014		2015		2016		2017		2018		2019		2020	
	IV		IV		IV		IV		IV		IV		IV		IV		IV		IV		IV	
Барилга	575.1		629.8		763.3		814.0		891.6		907.5		933.1		835.5		865.0		912.2		932.8	
Боловсруулах үйлдвэрлэл	431.1		532.3		632.2		638.1		659.4		681.4		285.4		326.1		317.2		333.8		339.3	
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	577.5		1,035.0		1,347.6		1,083.7		1,178.4		1,383.5		1,122.4		1,525.1		1,634.7		1,788.7		1,897.6	
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	21.4		41.6		105.0		103.6		133.1		299.8		389.1		300.5		295.1		316.1		237.4	
Мэдээлэл, холбоо	185.4		219.8		224.3		192.3		180.9		178.6		145.8		128.9		142.5		146.9		151.5	
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	83.2		111.8		139.3		159.0		168.5		179.5		183.6		185.7		198.2		214.2		267.6	
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	66.7		78.3		80.7		71.0		59.0		57.7		55.0		59.6		122.2		149.1		177.8	
Уул уурхай, олборлолт	5,692.8		9,626.1		13,051.3		15,109.5		15,419.7		15,360.0		11,518.3		12,825.8		14,566.8		16,366.1		17,753.2	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	388.0		436.9		502.7		508.5		552.7		593.5		599.6		650.8		676.3		699.3		710.7	
Ул хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	54.3		106.6		124.3		128.9		135.9		142.5		146.0		164.4		180.3		202.9		211.1	
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	36.3		42.6		47.2		49.8		58.0		61.6		64.6		69.4		72.7		75.9		76.7	
Нийт	8,444.7		13,332.7		17,668.4		19,579.3		20,247.0		20,696.3		16,277.5		18,019.9		20,223.0		22,555.7		24,205.7	

Эх сурвалж: МОНГОЛБАНК